



МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ САНАЛ

Одоо УИХ-аар хэлэлцэж байгаа Төсвийн тухай хуулийн төсөл нь юуны өмнө уул уурхайн салбарын орлогын ачаар огцом тэлж буй Монгол Улсын төсвийн төлөвлөлт, хуваарилалт ба зарцуулалтыг улс орны эрчимтэй хөгжил дэвшил, ард иргэдийн сайн сайхан амьдралыг хангах шийдвэрлэх хүчин зүйл болгоход чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд тулгуур ач холбогдолтой юм.

Энэхүү хуулиас өмнө 2010 оны 6-р сард Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг УИХ-аас батлан гаргасан бөгөөд ноднин Төсвийн тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барихаас өмнө болон өргөн барьснаас хойш янз бүрийн түвшинд тухайлбал, Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд болон орон нутагт бүсчилсэн байдлаар хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг явагдаж төсөлд зарим өөрчлөлт орсон байна.

Уг хуулийн төслийн одоогоор олон нийтэд танилцуулсан (УИХ-ын вэб хуудаснаас татаж авсан) хувилбарын зүйл, заалтуудын талаар Нээлттэй Нийгэм Форум, “Иргэд Төсвөө Хянана” иргэний нийгмийн сүлжээнээс дараах байр суурийг илэрхийлж байна.

Хуулийн төсөлд төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах, орон нутагт төсвийн эрх мэдлийг шилжүүлэхтэй холбоотой заалтууд орсныг дэмжиж буйгаа илэрхийлэхийн зэрэгцээ хуулийг эцэслэн батлахдаа дараах зарчмуудыг илүү тодруулан суулгаж өгөх талаар онцгойлон анхаарахыг бодлого боловсруулагчдад санал болгож байна. Үүнд,

- Төсвийн мэдээллийг нээлттэй болгох асуудлыг нарийвчлан зохицуулах, тухайлбал төсвийн үндсэн баримт бичгүүдийг интернэт, сонин хэвлэл, бусад хэлбэрээр олон нийтэд цаг алдалгүй, бүрэн гүйцэт хүргэж байх талаар тусгайлан зааж өгөх,
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилт, хяналтын үйл явцад иргэдийн оролцоог хангахын тулд төсвийн бүх баримт бичгийг боловсруулагдсан даруйд нь олон нийтэд

хүргэх, ингэхдээ хэлэлцүүлэг өрнүүлэх, санал авах хангалттай хугацаа байхаар зохицуулахын зэрэгцээ төсвийн сонголт, хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээг заавал зохион байгуулах үүргийг бүх шатны төсвийн холбогдох байгууллагуудад хүлээлгэх,

- Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хууль зөрчиж зарцуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нэн тодорхой болгож, ийм хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх механизмыг хуулинд нарийвчлан суулгаж өгөх,
- Төсвийн ил тод байдал, хариуцлага, олон нийтийн оролцоог зохицуулсан заалтуудыг төсвийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа бүх үйл ажиллагаанд хамруулах зарчмыг баримтлах зэрэг болно.

Дэмбэрэл овогтой Цэрэнжав



Хэвлэл мэдээллийн байгууллагад олон жил ажилласан. 2004-2006 онд Нээлттэй Нийгэм Форумын “Форум” телевизийн хөтөлбөрийн редактор, 2006-2008 онд Иргэний Холбооны хэвлэл мэдээллийн ажилтан, 2008 оноос “Ил Тод Байдал” сангийн ажилтан, гүйцэтгэх захирал, мөн 2009 оноос “Иргэд Төсвөө Хянана” иргэний нийгмийн сүлжээний зохицуулагч.

Уул уурхайн олборлох салбар, улсын ба орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдал, сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн сурталчилгааны мониторингийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.

“Иргэд Төсвөө Хянана” иргэний нийгмийн сүлжээ нь Монгол Улсын төсвийн үйл явц, түүний бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих зорилго бүхий төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны механизм бөгөөд Ардчиллын Боловсрол Төв, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, Захиргааны Шинэ Санаачилга, Зориг Сан, Нийгмийн Дэвшил, Эмэгтэйчүүд Хөдөлгөөн, Нээлттэй Нийгэм Форум, “Хүний Эрх Хөгжил” төв зэрэг байгууллагуудыг нэгтгэж байна.

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Нээлттэй Нийгэм Форум нь 2004 оны зургадугаар сард Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн /Соросын сан/-г өөрчлөн байгуулсны үндсэн дээр бий болсон Монголын төрийн бус байгууллага юм. Нээлттэй Нийгэм Форумын үндсэн зорилго нь чанартай мэдээлэл, судалгаа, олон талт хэлэлцүүлэгт тулгуурлан төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад иргэдийн идэвхитэй оролцоог дэмжихэд оршино.

ННФ иргэний нийгмийн бусад байгууллагатай нягт түншлэн ажиллахын сацуу парламент, засгийн газартай өргөн хүрээнд хамтран ажилладаг. Мөн улс оронд өрнөж буй нийгэм, эдийн засаг, улс төрийн үйл явцын талаар донор болон олон улсын байгууллагуудтай байнга зөвлөлддөг болно.

Эдгээр зарчмуудтай холбоотой тодорхой саналуудыг хуулийн төслийн холбогдох зүйл заалтаар бэлтгэснийг дор толилуулж байна.

ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦАД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ТУХАЙ

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь төсвийн байгууллага, албан тушаалтан Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна.

Энэ заалтыг илүү ойлгомжтой болгох шаардлагатай. Төсвийн байгууллага, албан тушаалтан, тусгай сан, гэрээлэгчид бүгдэд хамаарна, харин албан тушаалтан гэдэг үгний ард таслал байхгүй тохиолдолд төсвийн байгууллага зөвхөн тусгай сан, эсвэл гэрээлэгчтэй харьцах харилцаа хамаарна гэж ойлгогдохоор байна.

Мөн төрийн чиг үүрэг гэсэн ойлголтыг тодорхойлж өгөх хэрэгтэй. Төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хуулийн дагуу төсвөөс санхүүжилт авдаг төрийн ба орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой биш хуулийн этгээд, тухайлбал, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз төсвийн хуулийн заалтуудад хэрхэн хамаарах вэ? Мөн хамтарсан үйлдвэр, аж ахуйн нэгж болон төрийн өмчийн оролцооны хувь хэмжээ 50 хувиас бага байх зэрэг тохиолдолд энэ хууль хэрхэн үйлчлэхийг цаашид тодруулах нь зүйтэй.

3.3. Энэ хуульд заасан ил тод байдалтай холбогдсон зохицуулалт нь хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамаарах төсөвт болон энэ хуулийн 3.2-т заасан гүйцэтгэх ажилд хамаарахгүй.

Өнгөрсөн жилүүдийн туршлагаас үзэхэд төрийн ба төсвийн байгууллагууд Төрийн нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулийг ашиглан хүссэн мэдээллээ өөрийн үзэмжээр нууцлах явдал их байна. Иймээс гүйцэтгэх ажлаас бусад үйл ажиллагаанд хамаарах төсвийг төрийн нууцад хамааруулахыг хориглох заалт оруулж өгөх шаардлагатай.

5 дугаар зүйл. Төсвийн зарчим

5.1. Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална:

- 5.1.1. төсвийн тогтвортой байдлыг хангасан байх;
- 5.1.2. төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;

- 5.1.3. санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;
- 5.1.4. ил тод байдлыг хангасан байх;
- 5.1.5. хариуцпагатай байх.

Төсвийн ил тод байдал ба хариуцлагатай байх зарчмыг төсвийн хуулийн төслийн 5-р зүйлд тусгайлан нэрлэхийн зэрэгцээ авч хэрэгжүүлэх арга замуудыг задалж тайлбарласныг сайшаан тэмдэглэж байна.

6.4. Энэхүү хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагын зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

- 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;
- 6.4.2. төрийн чиг үүрэгт хамаарахгүй эсхүл арилжааны хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;
- 6.4.3. иргэн аж ахуйн нэгж төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг тэдгээрээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах;
- 6.4.4. хуульд өөрөөр заагаагүй бол аливаа бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх, гүйцэтгэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох;
- 6.4.5. төсвийн захирагч төсвийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргахгүй байх;
- 6.4.6. хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд эсвэл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх;
- 6.4.7. төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт эсвэл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй хойч үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх;
- 6.4.8. төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;

6.4.2-р заалтыг төсвийн аливаа байгууллага туслах үйл ажиллагаа явуулахыг шууд хориглосон байдлаар тодруулах.

6.4.6-д хуульд өөрөөр заагаагүй бол гэсэн нь хэт ерөнхий байгаа тул үүнийг өөрчилж заавал өрсөлдөөн, ил тод, нээлттэй байдлын болон “тэг суурьтай төсвийн төлөвлөлтийн” зарчмаар хэрэгжүүлэхээр тусгах.

6.5. Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлын зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

- 6.5.1. төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд олон нийтэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар мэдээлэх;
- 6.5.2. төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

- 6.5.3. төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж буй эсэхэд олон нийтээс хяналт тавих боломжоор хангах;
- 6.5.4. төрөөс үзүүлж буй аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж буй арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч буй бараа, ажил, үйлчилгээнд олон нийтээс хяналт тавих боломжоор хангах;
- 6.5.5. хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замын талаарх шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;
- 6.5.6. төсвийн талаарх олон нийтийн санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгаахаа бие даан шийдвэрлэх.

6.5-р зүйл бүхэлдээ татвар төлөгчдийн эрх ашиг, төсвийн үйл явцад иргэдийн оролцоог хангах үүднээс авч үзвэл маш чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Гэхдээ уг зүйлийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж болзошгүй, хэт ерөнхий шинжтэй заалтууд уг төсөлд орсон байна. Тухайлбал, 6.5.1-ийн “олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх” тухай заалтын “ойлгомжтой”, “хүртээмжтэй” гэдэгт ямар нэгэн шалгуур тогтоохгүй бол хэрэгжихгүй, албан тушаалтнууд өөрсдийн үзэмжээр хандахыг хязгаарлаж чадахгүй юм. Мөн “олон нийтийн оролцоог хангах”, “олон нийтийн саналыг харгалзан үзэх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэх механизм тодорхойгүй байна.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр энэ хуулийг батлагдсаны дараа төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоог хангах асуудлыг нарийвчлан зохицуулсан журмыг Сангийн яамнаас боловсруулж гаргах талаар яригдаж байсан. Гэхдээ бид энэ талын төсвийн үйл явц, хуваарилалт, зарцуулалтын ил тод байдлыг хангаж тодорхой шаардлага, механизмуудыг хуулинд түлхүү тусгах нь илүү үр дүнтэй гэж үзэж байна. Төсвийн холбогдолтой өмнөх хууль тогтоомжинд ил тод байдлыг хангах талаар ерөнхий үг, өгүүлбэр байсан ч олигтой хэрэгжээгүй явж ирснийг харгалзах хэрэгтэй.

Энд санал болгоход, төсвийн баримт бичгийг вэб сайтад тавих, ном эмхэтгэл болгон хэвлүүлж тараах, эсвэл шууд хувилж өгөхийн зэрэгцээ төсвийн эдийн засгийн ангилал, эдийн засаг, нийгмийн тодорхой салбар, нийслэл, дүүрэг, аймаг сумдаар задалж товч бөгөөд тодорхой тайлбар, танилцуулга бэлтгэн тухайн төсөвт хамаатай, түүнийг бүрдүүлдэг татвар төлөгчид буюу үр шимийг хүртдэг иргэдэд хүргэдэг, үүгээрээ олон нийтийн анхаарал, хараа хяналт, оролцоог бий болгох учиртай. Наад зах нь батлагдсан төсвөө хүлээж авсан төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн менежерүүд хэвлэлийн хурал зарлах зэргээр олон нийтэд хандаж сурах нь наад захын соёл юм. Мэдээж хэрхэн зарцуулснаа ч дараа нь бас л ил тод танилцуулах ёстой.

Бусад оронд өргөн дэлгэрсэн Иргэдийн төсөв зэрэг олон нийтэд зориулж график дүрслэл, тодруулга, жишээ баримтаар ойлгомжтой болгосон албан ёсны танилцуулгыг боловсруулан гаргаж үүнийгээ төсвийн баримт бичгийн нэг хэсэг болгох, үүний тулд иргэний нийгмийн байгууллага, судлаачидтай хамтран ажиллах талаар хуулинд зүйл, заалт оруулахыг уриалж байна.

Наад зах нь төсвийн баримт бичгийг боловсруулж дуусгаад албан ёсоор өргөн барьсан бол тэр мөчөөс олон нийтэд ил тод болох зарчим үйлчлэх ёстой. Магадгүй, өргөн барьсан өдрөө вэб сайтад мэдээлэх төдий биш, төсвийн эх баримт бичгийг хавсралт, дагалдах материалуудын хамт бүрэн эхээр тавих нь хамгийн зөв шийдэл байж болно. Өөрөөр хэлбэл өргөн барьсанд тооцогдохын тулд олон нийтэд мэдээлэгдсэн байх шаардлагыг оруулж өгөх зарчмыг уг хуулинд тусгаж өгөх боломжтой юм.

Төсвийн холбогдолтой аливаа шийдвэрт “олон нийтийн саналыг харгалзан үзэх” гэж заасан нь зөв хэрнээ хангалтгүй юм. Эрх бүхий албан тушаалтнууд олон нийтийн санал, дүгнэлт, байр суурийг төсвийн талаар шийдвэр гаргахдаа хэрхэн тусгаахаа бие даан шийдвэрлэх юм байна. Гэхдээ үүнийгээ тухай бүр олон нийтэд тайлагнадаг байх нь зүйтэй юм.

6.6. Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

- 6.6.1. төсвийн захирагч нь түүнийг томилсон Байгууллага, албан тушаалтны өмнө, эсвэл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;
- 6.6.2. төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харъяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх;
- 6.6.3. төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй;
- 6.6.4. төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх;
- 6.6.5. тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжүүлтээр хэрэгжүүлэх;

Төсвийн хариуцлагын зарчмууд онцгой ач холбогдолтой юм. Нэгэнт хариуцлага ярьж байгаа бол маш тодорхой зарчмыг тогтоох, тухайлбал төсвийн зориулалтыг өөрчилж дур мэдэн зарцуулах зэргээр төсвийн хууль тогтоомжийг зөрчих нь тухайн албан тушаалтны хувьд ноцтой үйлдэлд тооцогдож ажлаас чөлөөлөх үндэслэл болох ёстой. Нөгөө талаар төсвийн зөрчил, хяналт шалтгалт,

аудитын тайлан, авсан арга хэмжээ, хариуцлага хүлээлгэсэн тухай мэдээллийг олон нийтэд ил тод болгодог зарчмыг тогтоох, үүнийг хуулинд тодорхой тусгах шаардлагатай.

8.3.8. Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батална;

Янз бүрийн шалтгаанаар УИХ тухайн жилийн төсвийг хуулийн хугацаанд батлан гаргаж чадахгүй байж болзошгүйг үгүйсгэх аргагүй. Орон нутгийн түвшинд иймэрхүү асуудал хэд хэдэн удаа гарч байсан. Жишээлбэл, нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 2010 оны төсөв батлагдажгүй олон сар болсон юм. Төсвийг хуулийн хугацаанд хэлэлцэж батлах шаардлагатай нь зүйн хэрэг боловч асуудлыг нарийн нягтлаж шийдвэрлэхийн оронд хугацаа тулгаж байгаад шахаж батлуулдаг тал бий. Сүүлийн жилүүдэд УИХ-аар төсөв хэлэлцэж байгааг харахад төсвийн 3,4-р хэлэлцүүлгийг сүүлчийн ганц хоёрхон өдөрт шуурхайлан явуулж тухайлбал, хөрөнгө оруулалтын жагсаалтыг цаг хугацаатай өрсөлдөх маягаар санал хураан баталж байгаа нь ажиглагддаг.

Дээрх дурдсан нөхцөл байдлуудыг харгалзан хэрхэн шийдвэрлэх тодорхой процедурийг хуулинд тусгах саналтай байна. Тухайлбал, улсын төсөв хугацаандаа батлагдаагүй тохиолдолд төсвийн харилцааг тусгай горимд шилжүүлэх зэрэг асуудал маш нарийн хуульчлагдсан байх ёстой.

Төсвийн хэлэлцүүлэг УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу явагдах тул Төсвийн тухай хуулинд хэлэлцүүлгийн явцын ил тод, нээлттэй байдлыг хангах зохицуулалтыг тусгахыг чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Тухайлбал, УИХ-ын гишүүдийн гаргасан санал бүрийг гишүүний нэрийн хамт, мөн санал хураалтын дүнг гишүүдийн нэрээр мэдээлж байвал олон нийт, сонгогчдын зүгээс хяналт тавих нөхцлийг бүрдүүлнэ.

8.4.1. аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлнэ;

8.4.2. аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 5-ны өдрийн дотор батална;

Дээрх заалтаас харахад орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал 10-хан хоногийн дотор төсвөө хэлэлцэн батлахаар тусгажээ. (Одоо мөрдөж байгаа хуулиар 20-иод хоногт багтаадаг байсан). Энэ нь орон нутгийн төсвийн үйл явцад олон нийтийг оролцуулах, тэднээр хэлэлцүүлэх, саналыг нь авах байтугай, ИТХ-ын төлөөлөгчид өөрсдөө төсвийн холбогдолтой материалыг судалж ажиллахад ч хангалтгүй хугацаа юм.

Иймээс орон нутгийн төсвийг хэлэлцүүлэх хугацааг сунгах, мөн төсвийн төслийг Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барихтай нэгэн зэрэг олон нийтэд бүтнээр хүргэж иргэдийн зүгээс саналаа хэлэх, хэлэлцүүлэг өрнүүлэх, улмаар өөрсдийн сонгосон төлөөлөгчөөр дамжуулан ИТХ-д оруулах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой заалтыг хуулийн төсөлд оруулах шаардлагатайг өнөөгийн бодит байдал харуулж байна.

8.4.5. аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн батлагдсан төсвийг 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Энэ хугацааг багасгах боломжтой гэж үзэж байна. Учир нь аймаг, нийслэлийн төсвийг хэлэлцэн батлах үйл явц бүхэлдээ 10-хан хоног үргэлжилж байхад батлагдсан төсвийг Улаанбаатар руу Сангийн Яаманд хүргүүлэхэд сумдын төсөв батлагдсанаас хойш 11 хоног зарцуулж байгаа нь ойлгомжгүй бөгөөд төсвийг юуны түрүүнд дээд шатны байгууллагад зориулж батлуулж байгаа мэт сэтгэгдэл төрөхөөр байна.

8 дугаар зүйл. Төсвийн цаглабар

8.1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг дараах цаглабарын цагуу боловсруулж, батална:

8.1.1. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдээллийн төслийг жил бүрийн ...

Хуулийн төслийн 8-р зүйлд заасан цаглабарууд нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хязгаар, Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн жилийн төсөв, аймаг, нийслэлийн жилийн төсөв, мөн Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв, орон нутгийн жилийн төсвийн гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан зэрэг баримт бичгийн боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх төдийгүй ил тод болгож олон нийтэд хүргэхэд хамаатай гэж үзэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл тухайн баримт бичгийг заавал олон нийтэд мэдээлж байж хүргүүлсэнд тооцох нь төсвийн үйл явцад иргэдийн оролцоо, хяналтыг хангах чухал нөхцөл юм.

8.1.4. Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баталснаас хойш ажлын 7 хоногийн дотор хэвлэн нийтлэнэ.

8.3.6. Засгийн газар төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш ажлын 3 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ;

8.7.5.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн сар, улирлын батлагдсан гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 15-ны өдрийн дотор олон нийтэд хэвлэн мэдээлнэ.

8.9.5.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн гүйцэтгэл болон аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайланг олон нийтэд хэвлэн мэдээлнэ.

Мөн дээрх зүйлд төсвийн янз бүрийн шатны баримт бичгүүдийг “хэвлэн нийтэлнэ”, “олон нийтэд мэдээлнэ”, “олон нийтэд хэвлэн мэдээлнэ” гэх зэргээр зарчмын ялгаагүй мэт боловч өөр өөр үгээр тодорхойлсон нь бүгдээрээ хэт ерөнхий байна. Энэ чухам юуг хэлж байна вэ? УИХ, Засгийн газар, Сангийн яамны вэб сайтад тавигдахыг хэлэх үү, эсвэл заавал өдөр тутмын сонин, “Төрийн мэдээлэл” сэтгүүлд хэвлэгдэхийг хэлэх үү? Бас товч мэдээлж тойм төдий танилцуулах биш заавал бүрэн эхээр нийтлэх тодорхой заалт ч үгүйлэгдэж байгаа юм. Бас Улсын Их Хурлаас тухайн жилийн төсвийг 11-р сарын 15-нд батлаад ямар хугацаанд ил тод болгохыг орхигдуулсан байна.

9.1. Улсын Их Хурал төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг батлах;

9.1.2.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж жил бүр улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв, тэдгээрийн тодоттолыг батлах;

9.1.3.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх;

9.1.4.улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвийг төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж, батлах;

9.1.5.төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих;

9.1.6.Засгийн газрын үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох.

Төсвийн талаарх УИХ-ын бүрэн эрхийг заахдаа “төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих” гэсэн нь хэт ерөнхий, тодорхойгүй, хамгийн гол нь хариуцлага тооцох асуудал огт дурдагдаагүй байна.

Төсвийн талаар Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлохдоо

10.1.10. Улсын Их Хурлын шийдвэрээр байгуулахаар хуульд зааснаас бусад улсын төсөвт байгууллагыг шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах;

гэжээ. Өөрөөр хэлбэл УИХ-ын хажуугаар Засгийн газар өөрөө ямар нэгэн хууль, хязгаарлалтгүйгээр төсөвт байгууллагуудыг бий болгох шийдвэр гаргаж орон тоо, төсвийн зардлыг нэмчихээд дараа нь

УИХ-д оруулж тулгах боломжтой харагдаж байна. Ингэж байгуулахаасаа өмнө УИХ буюу төсвийн болон холбогдох байнгын хороодод мэдээлж зөвшилцдөг, эсвэл орон тоо, төсвийн өөрчлөлтийг тодорхой хязгаарт багтаадаг байж болох юм.

9.1.6.Засгийн газрын үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох.

10.1.12. Засгийн газрын зээл болон улсын өрийн удирдлага, түүний стратегийг тодорхойлж, хэрэгжүүлэх;

9.1.6 ба 10.1.12 заалтууд нь УИХ-ын эрх хэмжээний буюу түүгээр батлуулан хэрэгжүүлэх ёстой асуудал гэж ойлгогдож байгаа тул тодруулах шаардлагатай.

Хуулийн төслийн 11-16-р заалтуудад Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, төсвийн байгууллагын бүрэн эрхийг нэг бүрчлэн зааж зарим нэг үүргийг хүлээлгэсэн боловч төсвийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг хангах, олон нийтэд мэдээлж тайлагнахыг орхигдуулсан байна. Хэрвээ бид төсвийн хяналтын үндсэн нөхцлийг ил тод, нээлттэй байдал гэж үзэж байгаа бол энэ нь төсвийг шууд захиран зарцуулдаг байгууллага, албан тушаатнуудын нэн тэргүүний үүрэг байх ёстой.

17 дугаар зүйл. Тусгай сан

17.1.Төрийн зарим чиг, үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгай сангаар дамжуулан гүйцэтгэж болно.

17.2. Тусгай сан нь Засгийн газрын тусгай сан. Орон нутгийн тусгай сан

Тусгай сангийн тухай 17-р зүйл нь Засгийн газрын ба орон нутгийн тусгай сангууд байж болохыг зөвшөөрсөн агуулгатай боловч ямар нэгэн хязгаарлалт алга байна. “Орон нутгийн тусгай санг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, орлого болон зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна” гэсэн мөртлөө тодорхой зохицуулсан зүйл заалт алга байна.

Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцооний тухай 19-р зүйлд:

19.3. Холбогдох байгууллага, албан тушаалтан төсвийн мэдээллийн тогтолцоонд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь оруулах, мэдээллийн үндсэн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах үүрэгтэй.

гэжээ. Цаашид зөвхөн байгууллага, албан тушаалтан биш, иргэд хүсэлт гаргаж энэ сангийн мэдээлэлтэй танилцах боломжтой байх хэрэгтэй.

Төсвийн орлогын тухай 22-р зүйлд:

22 дүгээр зүйл. Төсвийн орлого

22.1. Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлого, бусад орлогоос бүрдэнэ.

гэжээ. Бусад орлого гэж юу хэлж байгааг тодруулах шаардлагатай.

26 дугаар зүйл. Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага

26.1. Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана:

- 26.1.1. төсвийн зарчмуудыг мөрдлөг болгох;
- 26.1.2. макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх;
- 26.1.3. төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх;
- 26.1.4. төсвийн төслийг хөтөлбөр, төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр тодорхойлсон байх;

26.1.5. төсвөөс санхүүжих бүх байгууллагын төсвийг аль нэг ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд хамруулсан байх.

26.1.6. орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнана.

Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагыг тодорхойлсон 26-р зүйл, мөн түүнд дурдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудад олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлж иргэдээс санал авах тухай тусгагдаагүй тул нэмж оруулах шаардлагатай.

31 дугаар зүйл. Төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

31.1. Засгийн газар нэгдсэн төсөв, Нийгмийн даатгалын болон Хүний хөгжил сангийн төсвийн төслийг энэ хуулийн 31.2-д заасан танилцуулгын хамтэнэ хуулийн 8.3-д заасан цаглабарын дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

УИХ-д өргөн мэдүүлэхтэй нэгэн зэрэг олон нийтэд албан ёсоор танилцуулах арга хэмжээ заавал авах хэрэгтэй гэж үзэж байна. Үүнийг бусад оронд байдаг шиг хэвлэлийн хурал, эсвэл янз бүрийн төлөөллийг оролцуулсан уулзалт хэлбэрээр зохион байгуулж болох юм. Мөн төсвийн төслийн баримт бичгийг өргөн мэдүүлсэн өдрөө бүрэн эхээр танилцуулах нь чухал зарчим байх ёстой.

32 дүгээр зүйл. Улсын Их Хурал төсөв батлах

32.1. Улсын Их Хурал Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангасан улсын төсөв, Нийгмийн даатгалын болон Хүний хөгжил сангийн төсвийн төслийг энэ хуулийн 8.3-д заасан цаглабарын дагуу хуульчилан батална.

Өргөн мэдүүлсэн төсвийн төслийн хэлэлцүүлэг УИХ-ын дэгийн тухай хуулийн дагуу үе шаттайгаар явагдана гэж ойлгогдож байна. Гэхдээ Төсвийн онцгой ач холбогдлыг харгалзан хэлэлцүүлгийн явцад нээлттэй сонсголыг УИХ-ын түвшинд заавал явуулж байхаар тусгах нь зүйтэй.

33 дугаар зүйл. Тодотгол

33.1. Засгийн газар дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ:

Төсвийн тодотголын тухай заалтыг нэлээд тодотгож зарим асуудлыг нарийвчлан заах шаардлагатай юм. Тухайлбал, хугацааны хувьд УИХ төдийгүй олон нийт, төрийн бус байгууллагууд, хөндлөнгийн шинжээчид танилцах боломжийг олгохын зэрэгцээ тодотголын төслийг анх баталсан төсвийн төслийн нэгэн адил иж бүрэн, дэлгэрэнгүй байдлаар танилцуулах, төсвийн төслөө олон нийтэд ил болгох, төсвийн тодотголыг батлах үйл ажиллагааг төсөв батлахтай нэгэн адил шат дамжлагаар дамжуулах гэх мэт. Мөн тодотголоор төсвийг нэмэхгүй байх, ялангуяа хөрөнгө оруулалтын төслийн өртгийг зөвхөн хасч байх нь зүйтэй гэж үзэж байна.

36 дугаар зүйл. Үр дүнгийн гэрээ

36.1. Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч нь харъяалах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна.

36.2. Үр дүнгийн гэрээнд байгууллагын төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн төсөв, хүрэх үр дүн, түүнийг дүгнэх талаар тусгасан байна.

36.3. Үр дүнгийн гэрээний биелэлтийг харъяалах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.

36.4. Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн гэрээг дүгнэгч этгээд нь дараах арга хэмжээг авна:

36.4.1. төсвийн үр дүнг сайжруулах, хэрэгжилтмйг эрчимжүүлэх талаар үүрэг өгч, хянаж ажиллах;

36.4.2. хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох;

Үр дүнгийн гэрээ болон түүний хэрэгжилтийн явц болон үр дүнгийн тайланг олон нийтэд цаг алдалгүй танилцуулж байвал уг гэрээг дүгнэхэд олон нийтийн саналыг тусгах боломжтой.

40 дүгээр зүйл. Туслах үйл ажиллагаа

40.1. Төсвийн байгууллага дараах шаардлагыг хангасан тохиолдолд туслах үйл ажиллагаа явуулан орлого олж болно:

- 40.1.1. төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн, уг үйл ажиллагаанаас алдагдал учирвал нөхөх төсвийн бус эх үүсвэрийг төлөвлөсөн байх;
- 40.1.2. санхүүгийн тайлан болон үр дүнгийн гэрээнд уг үйл ажиллагааны талаар зохих ёсоор тусгасан;
- 40.1.3. байгууллагын хөрөнгийг зориулалт бусаар ашиглаагүй, ажилтныг үүрэгт ажлаас нь хөндийрүүлээгүй;
- 40.1.4. туслах үйл ажиллагаа эрхлэх нь тухайн төсвийн байгууллагын чиг үүрэг, үндсэн үйл ажиллагаанд харшлахгүй.

Хуулийн төсөлд Төсвийн байгууллагад туслах үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн бүхэл бүтэн бүлэг орсныг бид бүхэлд нь хасах саналтай байна. Энэ нь төсвийн байгууллагын зорилго, үйл ажиллагааны зарчимд нийцэхгүй төдийгүй төсвийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах, хөндлөнгийн байгууллага, компани, хүмүүсийн мөнгө, санхүүгийн нөлөөнд автахад хүргэх эрсдэлтэй гэж үзэж байна. Хяналт тавихад түвэгтэй бөгөөд төсвийн байгууллага төрийн өмч хөрөнгө, төсвөөс санхүүждэг хүний нөөц зэрэг давуу байдлаа ашиглаж зах зээлийн шударга өрсөлдөөнийг эвдэх болно.

Цаашилбал, төсвийн зарлагын хэмнэлт (41-р зүйл), төсвийн урамшуулал (42-р зүйл)-тай холбоотой мэдээллийг ил тод болгох нь маш чухал юм. Тухайлбал, төсвийн хөрөнгөөс өгч байгаа аливаа шагнал, урамшууллын нэгдсэн мэдээлийн санг хөтлөх, тэр нь олон нийтэд нээлттэй байх ёстой. “Төсвийн урамшуулал олгох хувь, хэмжээ, шалгуур үзүүлэлт, түүнийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэснийг хуулиар хязгаарлах зайлшгүй шаардлагатай.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦАД ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ТУХАЙ

Төсвийн тухай хуулийн төсөлд орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах тухай бүхэл бүтэн зүйл орсон нь Нэгдсэн төсвийн тухай өмнөх хуулинд байгаагүй шинэлэг зүйл юм.

Харин 2010 оны эхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд ажлын хэсэг байгуулагдаж Төсвийн тухай хуулийн төсөлд нэмж тусгахаар хэд хэдэн санал боловсруулж Иргэний танхимаар хэлэлцүүлсэн билээ. Тухайлбал,

47 дугаар зүйл. Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах

47.1. Сум, дүүргийн төсөв хэлэлцэх, төлөвлөх, батлах, гүйцэтгэлийг хангах явцад дараахь зарчмыг баримтална. Үүнд:

47.1.1. Орон нутгийн хөгжлийн сангаас авч хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулах;

47.1.2. Дээрх асуулгын дагуу орж ирсэн саналуудыг санал өгсөн иргэдийн тоог үндэслэн эрэмбэлэх;

47.1.3. Баг болон хороодын Иргэдийн нийтийн хурлаар эдгээр саналуудыг хэлэлцэн загварчилсан төсвийн дагуу тухайн баг хороонд оногдох хөрөнгийн хэмжээнд багтаан эхний нэн тэргүүний 6 (яагаад 10 биш гэж?!) саналыг сонгох;

47.1.4. Эдгээр саналыг сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн өргөтгөсөн хуралд танилцуулах иргэд, мөн тогтоосон квотийн дагуу хуралдаанд таслах эрхтэйгээр оролцох иргэдийг баг, хороодын Иргэдийн нийтийн хурлаас санал хураан томилох;

47.1.5. Сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн өргөтгөсөн хурлаар баг, хороодоос гаргасан нэн тэргүүний саналуудыг үндэслэн олонхийн саналыг авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлах;

47.1.6. Иргэдээс санал гаргаагүй аливаа төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг хориглох;

47.2. Иргэдийн төлөөлөгчдийн өргөтгөсөн хурлын дэгийн тухай үлгэрчилсэн журмыг хууль зүйн асуудал хариуцсан төрийн төв байгууллага тогтооно.

47.3. Аймаг, нийслэлд улсын төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Сангийн яамны худалдан авах ажиллагааны нэгжийг Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулна.

47.4. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь 20 сая төгрөг хүртэлх өртөгтэй худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болно.

47.5. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам, заавар, жишиг баримт бичгийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллага баталж мөрдүүлнэ.

47.6. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд тухайн орон нутгийн ард иргэдийн

төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн ард иргэдийг өргөнөөр оролцуулах зарчим баримтална.

Эндээс үзэхэд иргэдийн оролцоог сум, дүүргийн түвшинд хангах нэлээд сонирхолтой механизмыг санал болгосон байжээ. Гэтэл одоо хэлэлцүүлж байгаа хуулийн төсөлд энэ механизм маш бүдэг туссан бөгөөд үүнд хамаатай 57-р зүйлд сум дүүргийн түвшинд иргэдийн шууд оролцоо байхгүй, зөвхөн төсвийн субъект болж чадахгүй буюу тодорхой эрх мэдэлгүй баг, хорооны иргэдийн нээлттэй хэлэлцүүлэг явуулж гарсан саналыг эрэмбэлж дээш уламжлах тухай заажээ.

57 дугаар зүйл. Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах

- 57.1. Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангаас авч хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.
- 57.2. Энэ хуулийн 57.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн хурал хэлэлцэн тэргүүн ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.
- 57.3. Энэ хуулийн 57.2-т заасны дагуу баг, хороодын иргэдийн Нийтийн хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлнэ.
- 57.4. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь энэ хуулийн 57.3-т заасан саналыг хэлэлцэж, батална.

Энэ нь хөдөөгийн мөн аймгийн төвийн багийн түвшинд ямар нэг хэмжээгээр хэрэгжих боломжтой бөгөөд “Тогтвортой амьжиргаа-2” төслийн нааштай туршлага бий. Харин хүн амын ихээхэн хэсэг оршин сууж байгаа нийслэл Улаанбаатар хотын хороодод хэрэгжихэд маш түвэгтэй байх болно. Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын тухай нарийн төвөгтэй асуудлаар хороодын хэмжээнд олон нийтийн нээлттэй, шударга санал асуулга явуулах эрх зүйн ба бусад орчин алга байна. Хороодын нийтийн хурлын хуралдааны механизм ч хангалттай төлөөлөл болж чаддаггүйг хэлэх хэрэгтэй. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцдогийг ашиглан иргэдийн өргөн оролцоог хангахгүйгээр тэдний өмнөөс шийдвэр гарган дээш хандах явдал хавтгайрсан.

Цаашилбал хороодын ИНХ-аас саналуудыг эрэмблэх аргачлал тодорхойгүй, дүүргийн төсөвт тусгах эсэх нь зөвхөн сайн дурын хэрэг гэж ойлгогдож, энд тодорхой зарчим, үүрэг хариуцлага харагдахгүй байна.

Ер нь аймаг, ялангуяа нийслэл Улаанбаатар хотын төсвийн үйл явцад иргэд, олон нийтийн илүү өргөн оролцоог хангаж өнөөгийнхөөс илүү нээлттэй, хяналттай болгох талаар нарийвчлан тусгахыг уриалж байна. Хэрвээ ингэхгүй бол орон нутагт ээлж дараалан эрх барьж буй хүмүүс нутгийн өөрөө удирдах ёс, зарчмаар халхавч хийж төрийн хяналтын механизмаас ямар нэг хэмжээгээр ангид байж орон нутгийн төсөв, сангууд (мөн газар, барилга байшин зэрэг үл хөдлөх хөрөнгө, өмч)-ыг үр ашиггүй, зориулалт бусаар, зарим тохиолдолд хууль зөрчин зарцуулах явдал гардаг төдийгүй түүнийгээ далдан өнгөрөхөд хүрдгийг өмнөх жилүүдийн жишээ, баримтууд бидэнд нотлон харуулж байна.

Аймаг нийслэлийн Засаг даргын бүрэн эрх (59-р зүйл), сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх (60-р зүйл)-ийг тодорхойлохдоо иргэдийн оролцоо, төсвийн ил тод байдлыг хангах үүрэг хүлээлгэх нь зүйтэй. Аймаг, нийслэл, сум дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг ИТХ-д танилцуулахаар дурдсан (61-р зүйл) боловч өргөн мэдүүлсэн төсвийг олон нийтэд танилцуулахыг орхигдуулсан байна.

Дүгнэж хэлэхэд, Төсвийн тухай хуулийн төслийн орон нутгийн төсвийн үйл явцтай холбоотой заалтуудад ил тод байдлын тухай тодорхой заалтууд үгүйлэгдсэн хэвээр, эсвэл хэт ерөнхий байна. Жишээлбэл, “Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан төсвийг олон нийтэд хүртээмжтэй, ил тод байдлаар мэдээлнэ” гэснийг улсын төсвийн холбогдолтой заалтуудын нэгэн адил тодорхой болгож нийтэд хүргэх арга хэлбэр, иж бүрэн байдал, хугацаа зэргийг зааж өгөх шаардлагатай.